



НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

□ Дүрэм, бүтэц, орон тоо батлах тухай □

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүрмийн 7.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2.2.1.3-д заалныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүтцийг хоёрдугаар, орон тооны хязгаарыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга (Х.Ганбат)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/03 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт удирдлагын хэлтсийн дарга (У.Бат-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЭРХЭМБУЛГАН

1550010092

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 04 дугаар сарын 25 өдрийн
1/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДҮРЭМ -дугаарт

Нэг. Нийтлэг үндэслэл

2024 он 04 сар 25 өдөр
УЛСЫН БҮРТГЭГЧ 658

1.1.Багахангай дүүргийн Эрүүл мэндийн төв /цаашид Эрүүл мэндийн төв гэх/ нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах, эрүүл мэндийн талаар төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомж, тушаал шийдвэр, стандарт, арга аргачлал, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, анхан шатны болон үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээг үзүүлэх амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тасаг, яаралтай тусламж, түргэн тусламж, лаборатори бүхий Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа эрүүл мэндийн үйлчилгээний байгууллага мөн.

1.2.Эрүүл мэндийн төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал, шийдвэр, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3.Эрүүл мэндийн төв нь үндэсний болон салбарын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, стратеги, Нийслэлийн болон дүүргийн засаг даргын мөрийн хөтөлбөр болон холбогдох бусад хөтөлбөр төлөвлөгөөтэй уялдсан байгууллагын стратеги төлөвлөгөөг 4 жилийн хугацаатайгаар нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргаар батлуулж хэрэгжүүлнэ.

1.4.Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн талаар Төрөөс баримтлах бодлого болон холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зонхилон тохиолдох өвчлөл, түүний эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дангаараа болон бусад мэргэжлийн төв, салбар, аж ахуйн нэгж байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран дүүргийн түвшинд зохион байгуулна.

1.5.Эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.4 дэх заалтуудад заасан төрийн албанд баримтлах үндсэн зарчмаас гадна

эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх, ил тод мэргэшсэн байх, хариуцлага хүлээх зарчмыг баримтална.

1.6.Эрүүл мэндийн төв нь оноосон нэртэй байна.

1.7.Эрүүл мэндийн төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, билэгдэл, туг, санхүүгийн харилцах данстай байна.

1.8.Эрүүл мэндийн төв нь албан ёсны цахим хуудастай байж, тогтмол шинэчлэн баяжуулж ажиллана.

Хоёр. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зарчим

Эрүүл мэндийн төв нь дараах зарчмыг баримтална.

2.1.Төрийн хуулийг чандлан сахиж шударга, ил тод байх (Хууль тогтоомжийг дээдлэн үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод байдлыг хангана);

2.2.Мэргэжлийн ур чадвартай байх (Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх мэргэжлийн өндөр түвшний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг эзэмшиж, түүнийгээ байнга хөгжүүлнэ);

2.3.Мэргэшсэн, тогтвортой байх (Хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, эмч эмнэлгийн мэргэжилтэн ажилтныг албан тушаалын шаардлагад нийцүүлэн томилно);

2.4.Ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагатай байх (Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд чанартай үзүүлэх төрийн албаны манлайлал, үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэнэ);

2.5.Тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт удирдамжийг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангана.

2.6.Хүнлэг, энэрэнгүй байх (Үйлчлүүлэгчийг дээдлэн хүнлэг, энэрэнгүй хандаж тохирсон оношилгоо, эмчилгээ, бусад тусламж, үйлчилгээг үзүүлнэ);

2.7.Бүтээлч, санаачлагатай байх (Аливаа асуудалд шинжлэх ухаанч байдлаар хандаж, шинэ техник, технологи, инновацийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан бүр хариуцсан ажилдаа бүтээлч санаачлагатай байна);

2.8.Суралцагч хамт олон байх (Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага, нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний аргуудаас байнга суралцаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр харилцан сургагч, суралцагч хамт олон байж, эдгээрийн сурч хөгжих, ахиж дэвших орчныг бүрдүүлнэ);

2.9.Иргэд олон нийтэд түшиглэх (Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж, өөрийн үйл ажиллагаагаар тэдний итгэл, хүндэтгэлийг хүлээж, харилцан хамтарч ажиллана);

2.10.Хяналт, үр дүнг чухалчлах (Дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг байнга үнэлэн дүгнэж, сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах);

Гурав. Эрүүл мэндийн төвийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл

3.1.Алсын хараа

Чадварлаг хүний нөөц, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, хамрах хүрээг нэмэгдүүлж жишигт нийцсэн эрүүл мэндийн төв болох

3.2.Эрхэм зорилго

Дүүргийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай, жигд хүртээмжтэй чанартай үзүүлнэ.

3.3.Үнэт зүйл:

3.3.1.Байгууллагын соёл

3.3.2.Үйлчлүүлэгч болон ажилчдын сэтгэл ханамж, итгэл

3.3.3.Мэргэшсэн ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц

Дөрөв. Эрүүл мэндийн төвийн үндсэн чиглэл, эрх, үүрэг

4.1.Эмнэлгийн үндсэн чиглэл.

4.1.1.Дүүргийн хүн ам болон дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч байгаа харъяаллын бус иргэд, дүүргийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа босоо тэнхлэгийн А0101 авто зам, төмөр замаар дамжин өнгөрч байгаа иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хуулийн дагуу харъяалал харгалзахгүй үзүүлэх

4.1.2.Амбулаторийн тусламж үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх

4.1.3.Хэвтүүлэн эмчлэх тасгийг дотор, хүүхэд, халдвар, сэргээн засах чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх

4.1.4.Эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор 24 цагаар яаралтай тусламж болон түргэн тусламжийг үзүүлэх.

4.1.5.Дүүргийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, хянах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах хууль тогтоомж, заавар журмын дагуу чанартай зохион байгуулах.

4.1.6.Анагаах ухааны дэвшилтэт технологи, ололт амжилт, арга технологи, инновацийг эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлэн үр дүнг тооцож санал боловсруулан ажиллах;

4.1.7.Нарийн мэргэжлийн эмчийн оношилгоо шаардлагатай, лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад тусламж үйлчилгээ авах үйлчлүүлэгчийг тээвэрлэж, хүлээлгэн өгөх.

4.2.Эрүүл мэндийн төвийн эрх, үүрэг.

4.2.1.Эрүүл мэндийн төвийн эрх:

4.2.2.Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, Харьяалах дээд байгууллагын тушаал, шийдвэр, хөгжлийн хөтөлбөр, төсөл стандарт заавар зөвлөмжийг зохион байгуулах биелэлтийг хангах, гүйцэтгэлийг хянах;

4.2.3.Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, нөөц, төсвийг бүрдүүлж, хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

4.2.4.Дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт

гаргах;

4.2.5. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд тулгамдсан асуудлаар нотолгоонд суурилсан үндэслэл бүхий санал боловсруулан холбогдох дээд байгууллагад танилцуулах, шийдвэрлүүлэх;

4.2.5.1. Бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

4.2.5.2. Чанартай тусламж, үйлчилгээг стандартын дагуу хүртээмжтэй үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох дээд байгууллагад байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.2.5.3. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, нийслэлийн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, ном товхимол, зөвлөмж заавар хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох;

4.2.5.4. Олон улсын байгууллага, гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар харьяалах дээд байгууллагатай зөвшилцөж харилцан ойлголцлын санамж байгуулах;

4.2.5.7. Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр тусламж, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн ажиллах;

4.2.5.8. Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад эрх;

4.3. Эрүүл мэндийн төвийн үүрэг:

4.3.1. Эрүүл мэндийн төв нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын журам боловсруулах, хэрэгжилтийг хангах;

4.3.2. Дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн анхан болон үндсэн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай, аюулгүй, хүртээмжтэй үзүүлэх;

4.3.2.1. Дүүргийн онцлогоос шалтгаалан анхан шатны тусламж үйлчилгээ болон амбулаториор үйлчлүүлэгчдэд үзлэг, оношилгоо, эмчилгээг батлагдсан стандарт технологи, эмнэл зүйн удирдамжийн дагуу хийж, оношийг тодруулан эмчилж, шаардлагатай бол журмын дагуу эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх

4.3.2.2. Дүүргийн нутаг дэвсгэрт эмнэлгийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй түргэн шуурхай хүргэх зорилгоор түргэн тусламж болон яаралтай тусламжийг стандарт, тушаал, заавар, журмын дагуу үзүүлэх

4.3.2.3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, өвчлөлийн байдал, нас баралтын шалтгааныг судлан дүгнэх, түүнийг бууруулах арга хэмжээ авах;

4.3.2.4. Үйлчлүүлэгчийг дээдлэн, үйлчилгээний ээлтэй, тав тухтай орчинг бүрдүүлэх; үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг 6 зорилтыг хэрэгжүүлж ажиллах

4.3.2.5. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан "Төсвийн тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль", "Шилэн дансны тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;



4.3.2.6.Эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, чанар сайжруулах арга аргачлал, хэрэгслийг нэвтрүүлэн, тогтмолжуулан ажиллах;

4.3.2.7.Эмнэлгийн ажилтны ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, холбогдох хууль тогтоомжийн дагуу тохирсон цалин хөлс олгох, мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлэх;

4.3.2.8.Эмнэлгийн ажилтны мэдлэг, мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;

4.3.2.9.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийж шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.3.2.10.Ажилтны нийгмийн баталгаа, тогтвор сууршилтай ажиллах нөхцөлийг хангах, холбогдох хууль тогтоомжийн дагуу тохирсон цалин хөлс олгох, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад тасралтгүй хамруулах;

4.3.2.11.Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллээр хангах;

4.3.2.12.Гамшиг, онцгой байдал, яаралтай тусламжийн бэлэн байдал хангах, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх нөөц, эрсдлийн сан бүрдүүлж, удирдаж ажиллах;

4.3.2.13.Барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх холбогдох хууль, стандартын шаардлагыг ханган ажиллах;

4.3.2.14.Төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүртгэл тооллогыг тогтоосон хугацаанд хийх, данснаас хасах, шилжүүлэх, устгал хийх асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх;

4.3.2.15.Эмнэлгийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн мэдээлэл, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээ болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах;

4.3.2.16.Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүрэг;

Тав. Бүтэц, зохион байгуулалт

5.1.Эрүүл мэндийн төвийн даргыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө.

5.2.Дарга нь төвийн үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах, үр дүнг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын өмнө тайлагнах, хариуцлага хүлээх үүрэг бүхий төрийн албан хаагч мөн.

5.3.Төвийн дарга нь удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

5.4.Төв нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмийн эмчилгээг зохицуулах хороо болон бусад шаардлагатай хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулна.



5.5.Төв нь байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өдөр тутмын асуудлаар зөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах удирдлагын багийг байгуулан ажиллуулна. Удирдлагын баг нь: Төвийн дарга, Чанарын менежер, Хүний нөөцийн менежер, ахлах нягтлан бодогч, Ахлах сувилагчийн бүрэлдэхүүнтэй ажиллана. Удирдлагын багийн ажиллах журмыг Төвийн дарга батална.

5.2.Эрүүл мэндийн төвийн даргын эрх, үүрэг

5.2.1.Эрүүл мэндийн төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, эмнэлгийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

5.2.2.Эрүүл мэндийн төвийн дарга нь жил бүр Төсвийн төвлөрүүлэн захирагчаар тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, биелэлтийг хангах, хагас, бүтэн жилээр тайлагнах, ил тод мэдээлэх;

5.2.3.Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилтийг оновчтой төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, зарцуулалтыг хянах, ил тод байдлыг хангах;

5.2.4.Салбарын санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан өөрийн байгууллагын зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээний хүрээ, тоо хэмжээг төлбөрийн аргад суурилан төлөвлөх, ажилчдын тоо, цалин хөлсийг тогтоох;

5.2.5.Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох, байгууллагын дотоод журам, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ойрын болон дунд хугацааны хөгжлийн стратеги төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;

5.2.6.Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сургалтад хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

5.2.7.Байгууллагын ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

5.2.8.Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ноогдуулах, гэрээг цуцлах;

5.2.9.Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах санал, арга хэмжээний үр ашгийг тооцож, ашигтай хувилбарийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;

5.2.10.Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилга, ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллах;

Зургаа. Санхүүжилт

Эрүүл мэндийн төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

6.1.Улсын төсвийн санхүүжилт

6.2.Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилт;

6.3.Үндсэн (Хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого), үндсэн бус (хууль тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого гэх мэт) үйл ажиллагааны орлого;

6.4.Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;

6.5.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;

6.6.Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

6.7.Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр;



Долоо. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

7.1.Эрүүл мэндийн төвийн даргын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар шийдвэрлэнэ.

7.2.Эрүүл мэндийн төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

7.3.Эрүүл мэндийн төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

Найм. Удирдлагын багийн гишүүдийн чиг үүрэг

Удирдлагын багийн гишүүд нь ажилчдад нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

8.1. Чанарын менежерийн чиг үүрэг

8.1.1.Байгууллагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг хариуцна.

8.1.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны үр дүнг хариуцан ажиллах;

8.1.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар, аргачлал боловсруулан хэрэгжүүлэх, хяналт тавих;

8.1.4.Тусламж, үйлчилгээтэй холбоотой үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж сайжруулах санал, шийдвэрийн төслийг Удирдлагын багт танилцуулан шийдвэрлэж ажиллах;

8.1.5.Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллана.

8.2. Хүний нөөцийн менежерийн чиг үүрэг

8.2.1.Байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан төлөвлөлт, үйл ажиллагааны ажлыг хариуцна.

8.2.3.Төвийн стратеги төлөвлөгөө болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хөгжлийн чиг хандлага, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

8.2.4.Хяналт-шинжилгээ, үнэлгээг тушаал, шийдвэр, журамд нийцүүлэн зохион байгуулах;

8.2.5.Статистик, даатгалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах;

8.2.6.Эмнэлгийн цахим мэдээллийн технологийг салбарын бодлого хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх, удирдан зохион байгуулах;

8.2.7.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг төлөвлөх, хяналт-үнэлгээг нэгдсэн удирдлагаар хангах, үр дүнг тооцох;

8.2.8.Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт сурталчилгаа болон хамтын



ажиллагааны төсөл хөтөлбөрийг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах;

8.2.9.Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллана.

8.3. Ахлах сувилагчийн чиг үүрэг

8.3.1.Сувилахуйн тусламж, үйлчилгээний үйл ажиллагааг хариуцна.

8.3.2.“Сувилахуйг хөгжүүлэх стратеги”, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн тогтолцоо, сургалт эрдэм шинжилгээний бүхий л орчинд сувилагч, эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтний манлайллыг бэхжүүлэх;

8.3.3.Сувилахуй, эмнэлгийн тусламж үйлчилгээг байгууллагын үндсэн зорилготой уялдуулан төлөвлөх, нэгдсэн арга зүйгээр хангах, хэрэгжүүлэх;

8.3.4.Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний үзүүлэх тусламж үйлчилгээний стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар, аргачлалын хэрэгжилтийг хангах, хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх;

8.3.5.Сувилах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, хяналтын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжүүлж ажиллах;

8.3.6.Шинэ сувилагч, туслах сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг ажлын байранд сургах арга хэмжээг хэрэгжүүлэх;

8.3.7.Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг олон нийттэй харилцах ур чадвар эзэмшүүлэх, үйлчилгээний соёлыг бий болгох.

Ёс. Байгууллагын үйл ажиллагаа болон багуудын ерөнхий чиг үүрэг

9.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын баг

9.1.1.Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

9.1.2.Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах, үйл ажиллагааг зохион байгуулах, чанар, эрсдэл, үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд хяналт тавих, дэмжин туслах, арга зүйн зөвлөгөө өгөх, зохицуулах;

9.1.3.Чанарын удирдлагааны тогтолцооны чиглэлээр ажилладаг эрх бүхий байгууллагууд, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, зөвлөл, иргэдийн төлөөлөлттэй хамтран ажиллах;

9.1.4.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын баг нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, халдвар сэргийлэлт, хяналтын баг, эрүүл мэндийн даатгал, статистик, эмийн сан, эмийн зохицуулах хороо, сувилахуйн баг, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хоол үйлдвэрлэл зэрэг багуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйгээр ханган, стандартын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

9.2. Халдварын сэргийлэлт, хяналтын баг

9.2.1.Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн биелэлтийг хангуулж хяналт тавьж ажиллах;

9.2.2.Эрүүл мэндийн байгууллагын ажилтан, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл болон бусад иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, тохиолдлыг эрт илрүүлж, тандалт судалгаа хийх, мэдээлэх, хариу арга хэмжээ авч, эрсдэлт хүчин зүйлийг тогтоох;

9.3. Эрүүл мэндийн даатгал, статистик,

9.3.1.Эрүүл мэндийн төвийн статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, нэгтгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэж эргэн мэдээллээр хангах;

9.3.2.Гүйцэтгэлийн санхүүжилтийг холбоотой үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, нэхэмжлэх, тайлагнах, танилцуулах, хянах;

9.3.3.Гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж буй оношийн хамааралтай бүлэг тус бүрээр судалгаа гаргаж, дүн шинжилгээ хийн, оношийн хамааралтай бүлгээр тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

9.4. Эмийн эмчилгээний зохицуулах баг

9.4.1.Эм зүйн тусламж үйлчилгээтэй холбоотой тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

9.4.2.Эм зүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах;

9.4.3.Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, эмэнд тэсвэртэй нянгийн шалтгаант өвчин үүсэхээс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хяналт үнэлгээ хийх;

9.4.4.Шинэ, эм, эмнэлгийн хэрэгслийг эмийн эмчилгээнд нэвтрүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, үйл ажиллагааг зохион байгуулах;

9.4.5.Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн биелэлтийг хангуулж хяналт тавьж ажиллах;

9.4.6.Тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхүйц оношилгоо, эмчилгээний дэвшилтэт арга технологийн чиглэлээр сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааг өргөжүүлэх төсөл хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах;

9.4.7.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг хянаж ажиллах;

9.4.8.Эмнэлгийн мэдээллийн ил тод байдлыг хангах, сошиал медиа, чатбот хэрэгслийг хослуулан үйлчилүүлэгчийг татах, эмнэлгийн онцлогийг олон нийтэд таниулах, идэвхижүүлэх ажлыг зохион байгуулах;

9.5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

9.5.1.Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах;



9.5.2.Холбогдох хууль, журам, тушаал шийдвэрийн дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах;

9.5.3.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны судалгаа хийж, тайланг мэдээг гаргаж танилцуулах;

9.5.4.Иргэд рүү чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт зохион байгуулах, мэдээ, мэдээллээр хангах, эрт илрүүлэг оношилгоо, шинжилгээний ач холбогдлыг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулах;

9.6. Дотоод хяналтын ажилтан

9.6.1.Дотоод хяналтын ажилтан нь байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, шаардлагатай тохиолдолд байгууллагын тодорхой чиг үүрэгт үнэлгээ хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргах;

9.6.2.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөндлөнгийн байгууллагаар хийлгэх үнэлгээг зохион байгуулах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, тушаал, гэрээ хянах;

9.7. Захиргаа, хүний нөөц

9.7.1.Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратегитай уялдуулан эмнэлгийн хүний нөөцийн хэрэгцээ, нийгмийн баталгаа, хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

9.7.2.Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай холбоотой тушаал, шийдвэрийн төслийг боловсруулах, албан хаагчтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлэх;

9.7.3.Ажилтны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж батлуулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх;

9.7.4.Байгууллагын удирдлагын бичиг баримт, эмнэлгийн тусламж үйлчилгээнээс бусад үйл ажилагаатай холбоотой бичиг баримтыг боловсруулах, батлуулах, тайлан мэдээг нэгтгэн гаргаж байгууллагын удирдлагаар хянуулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллах.

9.7.5.Эмч, эмнэлгийн ажилчдыг тасралтгүй сурах нөхцлийг бүрдүүлж, байгууллагын дотоодын сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалт, холбогдох сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах.

9.8. Санхүү

9.8.1.Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах;

9.8.2.Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг Монгол Улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах;

9.8.3.Салбарын санхүүжилтийн шинэчлэл, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан өөрийн байгууллагын зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээний хүрээ, тоо

хэмжээг төлбөрийн аргад суурилан төлөвлөн хэрэгжүүлэх;

9.8.4.Эрүүл мэндийн төвийн үндсэн чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, нөөц, үйл ажиллагааг холбогдох хууль эрхзүйн хүрээнд төлөвлөх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэнд төлөвлөлт хийж, удирдлагыг мэдээллээр хангах;

9.8.5.Төсвийн тухай хуулийн дагуу жил бүрийн төсвийн төсөөллийг батлуулан хүргүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зохион байгуулах;

9.8.6.Гүйцэтгэлийн санхүүжилтийн судалгаанд үндэслэн хамгийн үр ашигтай тусламж, үйлчилгээрүү чиглэсэн төлөвлөлтийг боловсруулан зах зээлд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.9. Аж ахуйн үйл ажиллагаа

9.9.1.Нярав байгууллагын хангамж үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагааг бүрэн хариуцна.

9.9.2.Эмнэлгийн барилга, ус, дулаан хангамж, эд хогшил, эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээтэй холбогдолтой мэдээллийн сан үүсгэх, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах;

9.9.3.Байгууллагын гадна болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ, харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллах;

9.9.4.Эмнэлэгт эмчлүүлэгчдийн хоол үйлдвэрлэлийг холбогдох стандарт, удирдамж, зааврын дагуу бэлтгэх, боловсруулах, түгээхэд ажлын байрны болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж ажиллах;

9.9.5.Эрүүл мэндийн төвийн хэмжээнд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийг хүлээн авах суурилуулах, үйл ажиллагаанд оруулах, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, үзлэг, үйлчилгээ хийх, холбогдох маягт, баримт бичгүүдийг стандартын дагуу хөтөлж зэрэг үйл ажиллагааг байгууллагын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй хамтран зохион байгуулах, удирдлагыг мэдээллээр ханган ажиллах;

9.9.6.Ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн байнгын, хэвийн, найдвартай ажиллагааг хангах, нэгдсэн мэдээллийн цахим санд эмнэлгийн мэдээллийг оруулах, тогтмол баяжуулах;

9.9.7.Шаардлагатай сэлбэг, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн захиалгыг авч нэгтгэх, үзлэг, засвар, үйлчилгээ хийх, холбогдох техникийн бичиг баримт, мөрдөгдөж буй стандарт, удирдамжуудыг мөрдөж ажиллах, тоног төхөөрөмжгүй харьцан ажилладаг эмч, мэргэжилтэн, ажилтанд шаардлагатай зүйлсээр хангах.

9.10. Мэдээлэл технологи

9.10.1.Хүний нөөцийн хэсэг хариуцаж ажиллана.

9.10.2.Мэдээллийн технологийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж, тушаал журам, төслийн хүрээнд төлөвлөгөө боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах;



9.10.3.Эмнэлгийн кабелийн сүлжээ, мэдээллийн технологийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, хяналт тавьж хөгжүүлэх;

9.10.4.Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухайн хуулийн хүрээнд эмнэлгийн мэдээлэл аюулгүй байдлыг хангах, хэрэгжүүлэх;

9.10.5.Байгууллагын цахим хуудасны шинэчлэл, мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

9.10.6.Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэж буй цахим программын ашиглалт, хамгаалалт, хөгжүүлэлтийг хийн, хяналт тавих;



Арав. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

10.1.Эрүүл мэндийн төвийн даргын саналыг үндэслэн Нийслэлийн Эрүүл мэндийн газрын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

—oOo—

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 09 дугаар сарын 02 өдрийн
11/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ОРОН ТООНЫ
ДЭЭД ХЯЗГААР

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Орон тооны дээд хязгаар
1	Багахангай Эрүүл Мэндийн төв	45

Жич: Орон тооны хязгаарт үндсэн болон гэрээт ажилтан хамаарах ба эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоо хамаарахгүй.



Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 01 дугаар сарын 02 өдрийн
Аж. дугаар тушаалын гуравдугаар хавсралт

01023070010
9077/tee & /C5122050

БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БҮТЭЦ

